



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 09 өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн хувьцааг нэмж гаргах,
олон нийтэд санал болгох тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.4, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 3.4, 6.11.3, 6.11.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмж хувьцаа гаргах замаар нэмэгдүүлж, компанийн гаргасан нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 231,305,936 (хоёр зуун гучин нэгэн сая гурван зуун таван мянга есөн зуун гучин зургаан) ширхэг энгийн хувьцаан дээр нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 119,157,603 (нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурван) ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан олон нийтэд санал болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн тул одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасны дагуу нэмж гаргаж буй 119,157,603 (нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурван) ширхэг энгийн хувьцаа нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн нийт гаргасан хувьцааны 34 хувьтай тэнцэх бөгөөд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсаны үр дүнд одоогийн хувьцаа эзэмшигч болон олон нийтийн эзэмших хувь дор дурдсанаар өөрчлөгдөхийг баталгаажуулсугай:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
		Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо
1	Төр	100 хувь	231,305,936	66 хувь	231,305,936
2	Олон нийт	-	-	34 хувь	119,157,603

4. Энэ тогтоолын биелэлтийг хангаж, зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, нэмж гаргаж буй хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д бүртгүүлэх, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулахтай холбоотой бусад шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/, Гүйцэтгэх захирал /Х.Алтай /нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ,
САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.11.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрэмд дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай. Үүнд:

- 1.1. Дүрмийн 6.11.4 дэх заалтын “солих” гэсний дараа “хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох” гэж тус тус нэмэх;
- 1.2. Дүрмийн 2.2 дахь хэсгийг “Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа байна” гэж, 7.3.7 дахь заалтыг “компанийн өрийн хэрэгсэл гаргах” гэж тус тус өөрчлөн найруулах;
- 1.3. Дүрмийн 1.10 дахь хэсгийн “Чингис хааны нэрэмжит талбай 3” гэснийг “Д.Сүхбаатарын талбай 3” гэж, 7.3.8 дахь заалтын “хэлэлцэж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх” гэснийг “хэлэлцэж шийдвэрлэх” гэж тус тус өөрчлөх;
- 1.4. Дүрмийн 3.3 дахь хэсгийг хүчингүй болгох.

2. Энэ тогтоолын 1-т заасан нэмэлт, өөрчлөлтийг тусгасан “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг холбогдох журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн, нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ,
САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН